**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/029/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2026 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Цахим актив аудит ХХК -ын Аудитор: Д.Балжинням<br>Утас:70432545 Цахим хаяг: Damiranbaljinnyam573@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОА-2026/177/НА-СТА-ТШЗ

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан. ........ 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 10
3.1. Зөвлөмж ........ 10
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 26
**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл** ........ 26

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 202

танай ____________-ны №____________-т

ЧАНДМАНЬ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
ЭМЧ Д.ЧУЛУУНЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Онцлох асуудал нь тайлант оны эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл 6.9 сая төгрөг, үүний 2.0 сая төгрөг нь он дамжсан үлдэгдэл байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд урсгал төсвөөс 35.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, харьяа дээд шатны байгууллага болон хандив тусламжаар 27.3 сая төгрөг, KFW олон улсын байгууллагын тусламжаар түргэн тусламжийн машин 200.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

8426000512

**Бусад асуудал**

Үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 хөтөлбөр, 9 зорилтын хүрээнд 90 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлтийг 96.6 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **233,865,927.91** | **207,741,804.99** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 58,466,310.62 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 58,466,310.62 |
| **3121** | **Төгрөг** | - | 58,466,310.62 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 58,466,310.62 |
| **33** | **АВЛАГА** | 175,524,008.54 | 53,480,372.15 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 70,202.70 | 1,706,272.31 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 175,453,805.84 | 51,774,099.84 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 58,341,919.37 | 95,795,122.22 |
| **351** | **Түүхий эд материал** | 35,119,479.47 | 46,454,499.97 |
| 35130 | Эм боох материал | 35,119,479.47 | 46,454,499.97 |
| **354** | **Хангамжийн материал** | 23,222,439.90 | 49,340,622.25 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 941,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,615,500.00 | 2,538,820.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,580,000.00 | 3,421,760.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19,026,939.90 | 42,438,342.25 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,239,637,784.43** | **1,543,264,161.88** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,239,637,784.43 | 1,543,264,161.88 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,224,891,784.43 | 1,528,518,161.88 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,358,747,535.00 | 1,308,274,135.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (394,022,214.80) | (437,684,129.56) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 59,153,442.00 | 266,036,842.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (20,163,351.51) | (23,084,351.03) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 314,719,930.38 | 492,203,167.38 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (113,375,735.94) | (133,330,720.96) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 66,841,906.00 | 104,243,444.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (47,059,726.70) | (48,190,224.95) |
| 39217 | Ном | 50,000.00 | 50,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 14,746,000.00 | 14,746,000.00 |
| 39301 | Програм хангамж | 732,000.00 | 732,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (732,000.00) | (732,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,746,000.00 | 14,746,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,473,503,712.34** | **1,751,005,966.87** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,440,395,577.79** | **1,751,005,966.87** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,440,395,577.79 | 1,751,005,966.87 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 214,581,860.80 | 214,581,860.80 |
| 51101 | Өмч: - төрийн | 214,581,860.80 | 214,581,860.80 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 899,030,923.56 | 1,251,633,281.57 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 899,030,923.56 | 941,022,892.49 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 310,610,389.08 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 326,782,793.43 | 284,790,824.50 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,473,503,712.34** | **1,751,005,966.87** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,146,153,383.70** | **1,839,551,781.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **436,477,779.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 436,477,779.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 436,477,779.50 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 436,477,779.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,146,153,383.70** | **1,403,074,002.10** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 120,439,846.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 120,439,846.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 60,838,700.00 | 64,152,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,838,700.00 | 64,152,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,085,314,683.70 | 1,218,482,056.10 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,085,314,683.70 | 1,218,482,056.10 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,165,221,970.34** | **1,513,953,411.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,165,221,970.34** | **1,513,953,411.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,165,221,970.34 | 1,407,055,236.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 697,933,271.54 | 908,326,549.10 |
| 210101 | Үндсэн цалин | 365,532,566.91 | 388,039,820.62 |
| 210102 | Нэмэгдэл | 250,435,395.68 | 391,501,794.25 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 31,043,000.00 | 84,576,612.62 |
| 210104 | Урамшуулал | 50,922,308.95 | 44,208,321.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 94,219,021.36 | 112,896,012.06 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,652,715.63 | 75,444,027.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,301,600.00 | 9,385,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,650,900.00 | 4,603,784.37 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,010,605.73 | 4,692,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,603,200.00 | 18,770,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 60,332,400.00 | 62,533,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,276,400.00 | 3,936,524.60 |
| 210302 | Түлш, халаалт | 56,056,000.00 | 56,049,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 2,546,975.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,604,290.00 | 36,419,635.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,796,300.00 | 2,399,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,249,790.00 | 25,897,020.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,364,150.00 | 2,834,165.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 495,500.00 | 594,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,584,050.00 | 1,337,600.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 114,500.00 | 3,357,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 125,054,894.97 | 80,810,647.81 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 111,587,018.97 | 72,569,457.81 |
| 210502 | Хоол, хүнс | 10,092,325.00 | 8,241,190.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,413,296.00 | 2,983,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 406,996.00 | 1,365,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 506,300.00 | 1,618,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,934,000.00 | 2,920,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,934,000.00 | 2,920,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,345,625.00 | 35,600,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 35,567,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 33,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 146,385,171.47 | 164,564,792.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,066,975.95 | 43,501,730.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 108,318,195.52 | 121,063,062.23 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 106,898,175.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 106,898,175.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 38,120,175.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 68,778,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(19,068,586.64)** | **325,598,370.40** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 14,987,981.32 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 14,987,981.32 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (14,987,981.32) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(19,068,586.64)** | **310,610,389.08** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **987,824,115.86** | **1,526,753,708.10** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **987,824,115.86** | **1,526,753,708.10** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 120,439,846.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 120,439,846.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 60,838,700.00 | 64,152,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,838,700.00 | 64,152,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 926,985,415.86 | 1,342,161,762.10 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 926,985,415.86 | 1,342,161,762.10 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **989,631,226.60** | **1,433,144,897.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **989,631,226.60** | **1,433,144,897.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **989,631,226.60** | **1,326,246,722.48** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 699,800,821.52 | 908,256,346.40 |
| 210101 | Үндсэн цалин | 366,422,850.72 | 387,969,617.92 |
| 210102 | Нэмэгдэл | 251,412,661.85 | 391,501,794.25 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 31,043,000.00 | 71,238,819.62 |
| 210104 | Урамшуулал | 50,922,308.95 | 57,546,114.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 90,770,500.00 | 114,691,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,563,900.00 | 77,150,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,301,600.00 | 9,385,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,650,900.00 | 4,692,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,650,900.00 | 4,692,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,603,200.00 | 18,770,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 60,332,400.00 | 62,533,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,276,400.00 | 3,936,524.60 |
| 210302 | Түлш, халаалт | 56,056,000.00 | 56,049,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 2,546,975.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,718,406.68 | 46,776,938.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,715,800.00 | 3,225,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,012,506.68 | 32,550,303.32 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,364,150.00 | 2,931,965.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,447,000.00 | 1,672,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,178,950.00 | 6,397,320.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 86,442,723.40 | 120,836,657.76 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 76,615,873.40 | 100,642,907.76 |
| 210502 | Хоол, хүнс | 6,688,650.00 | 9,849,750.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,138,200.00 | 10,344,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,521,300.00 | 4,983,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 430,000.00 | 3,365,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 506,300.00 | 1,618,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,934,000.00 | 2,920,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,934,000.00 | 2,920,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,345,625.00 | 38,380,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 37,897,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 33,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,765,450.00 | 26,868,080.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,765,450.00 | 26,868,080.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **106,898,175.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 106,898,175.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 38,120,175.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 68,778,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(1,807,110.74)** | **93,608,810.62** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **19,514,000.00** | **35,142,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,514,000.00** | **35,142,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 19,514,000.00 | 35,142,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 19,514,000.00 | 35,142,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(19,514,000.00)** | **(35,142,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (21,321,110.74) | 58,466,310.62 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 58,466,310.62 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

(Төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **214,581,860.80** | **284,790,824.50** | **941,022,892.49** | **1,440,395,577.79** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **214,581,860.80** | **284,790,824.50** | **941,022,892.49** | **1,440,395,577.79** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 41,991,968.93 | 41,991,968.93 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **214,581,860.80** | **284,790,824.50** | **983,014,861.42** | **1,482,387,546.72** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (41,991,968.93) | - | (41,991,968.93) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 310,610,389.08 | 310,610,389.08 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **214,581,860.80** | **242,798,855.57** | **1,293,625,250.50** | **1,751,005,966.87** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(Төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,545,626,200.00 | 1,433,144,897.48 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,545,626,200.00 | 1,433,144,897.48 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,438,645,500.00 | 1,326,246,722.48 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 920,152,500.00 | 908,256,346.40 |
| 210101 | Үндсэн цалин | 382,571,000.00 | 387,969,617.92 |
| 210102 | Нэмэгдэл | 404,301,500.00 | 391,501,794.25 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 71,280,000.00 | 71,238,819.62 |
| 210104 | Урамшуулал | 62,000,000.00 | 57,546,114.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 114,691,100.00 | 114,691,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 77,150,300.00 | 77,150,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,385,200.00 | 9,385,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,692,600.00 | 4,692,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,692,600.00 | 4,692,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,770,400.00 | 18,770,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 63,533,200.00 | 62,533,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,317,000.00 | 3,936,524.60 |
| 210302 | Түлш, халаалт | 56,056,200.00 | 56,049,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,160,000.00 | 2,546,975.40 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 53,684,600.00 | 46,776,938.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,370,000.00 | 3,225,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,435,000.00 | 32,550,303.32 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,333,400.00 | 2,931,965.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,443,800.00 | 1,672,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,102,400.00 | 6,397,320.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 159,353,700.00 | 120,836,657.76 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 134,953,700.00 | 100,642,907.76 |
| 210502 | Хоол, хүнс | 13,462,500.00 | 9,849,750.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,937,500.00 | 10,344,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 41,441,900.00 | 4,983,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 38,223,000.00 | 3,365,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,618,900.00 | 1,618,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,610,300.00 | 2,920,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,610,300.00 | 2,920,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 40,706,100.00 | 38,380,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,800,000.00 | 37,897,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 33,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 37,472,100.00 | 26,868,080.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,472,100.00 | 26,868,080.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 106,980,700.00 | 106,898,175.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 106,980,700.00 | 106,898,175.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 38,202,700.00 | 38,120,175.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 68,778,000.00 | 68,778,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,545,626,200.00** | **1,406,313,862.10** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 64,152,100.00 | 64,152,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 64,152,100.00 | 64,152,100.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,481,474,100.00 | 1,342,161,762.10 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,481,474,100.00 | 1,342,161,762.10 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **58,466,310.62** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] алдаа илрээгүй.

Аудитаар залруулагдаагүй 17,039.3 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрсэнд алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 16,638.1 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.1.1. Худалдан авалттай ажиллагаатай холбоотой

*Илрүүлэлт:* Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй, мөн нэг эмийг өөр өөр газраас олон янзын үнээр худалдан авч байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, эм баригч эмийн түүвэрт эмийн зарлага гаргахдаа тоо ширхгийн болон эмийн үнийн зөрүү үүсэж байгаагаас санхүүгийн тайлангийн эм боох бараа материалын зарлага, эцсийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэж байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" , Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2026 оны 01/103 албан тоотын заалтуудтай, батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж: Ерөнхий гэрээнд заасан эм эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийх.*

#### 3.1.2. Бараа материалын бүртгэл

*Илрүүлэлт:* Тайлант онд эм боох материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэсэнтэй холбоотойгоор эм боох материалын үлдэгдэл их байхад нөлөөлөл үүсгэх, мөн эм баригчийн ажилд хүндрэл учруулж байгаа зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/3 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 8 дугаар зүйлийн 8.2 –д “.Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.” 8.3.-д “Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ.”, гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* НББББББ-т байгууллагын эм боох материалын бүртгэлийг байгууллагын онцлог тохируулж өөрчлөлт оруулах, эм боох материалын бүртгэлээс, тусгай зориулалтын материалыг данс хооронд шилжүүлж бүртгэх.

#### 3.1.3. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 15 нэр төрлийн 17,019.3 мянган төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтын 10 дугаар зүйлийн 10.24-д "Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ", 10.26--д "Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Дараа тайлангийн хугацаанд дээрх хөрөнгүүдийн элэгдлийг орлогод хүлээн авсан онуудаас эхлэн нөхөж тооцон холбогдох данс бүртгэлд залруулга хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдаа, зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй, | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Тайлант онд эм боох материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэсэнтэй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 15 нэр төрлийн 17,039.0 мянган төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй, | 1 | 17,039.0 | | | | | 1 | 17,039.0 |
| **Дүн** | **3** | **17,039.0** | | | | | **3** | **17,039.0** |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |